

БАЯНТҮМБИЙН ХАДНЫ ЗУРГИЙН ДҮР, ДҮРСЛЭЛ

Ч. ЭНХТӨР¹, Ц. МӨНХБАТ²

¹ Ховд аймгийн Манхан сумын Бүрэн дунд сургуулийн захирал.

² Ховд аймгийн Манхан сумын Бүрэн дунд сургуулийн багш
e-mail: munkhbat_22@yahoo.com

Түлхүүр үг: Ховд аймаг, Манхан сум, Хадны зураг

ТОВЧ АГУУЛГА: *Ховд аймгийн Манхан сумын Баянтүмбэ уулын энгэр болон наран ээвэр хэсгээс 100 гаруй дүрслэлтэй хадны зураг олов. Уг хадны зураг дахь амьтдын дүрслэл, тэдгээрийг урласан арга барилаас нь харвал эдгээр сүг зургууд нь палеолитийн үеэс хүрэл зэвсгийн үед холбогдох ажээ. Энэхүү өгүүллээр Баянтүмбийн хадны зургийг олны хүртээр болгож шинжлэх ухааны эргэлтэнд оруулахыг зорив.*

Ховд аймгийн Манхан сумын нутагт бидний өвөг дээдсийн үлдээсэн олон гайхамшигтай дурсгалууд байдаг. Тэдгээр дурсгалуудын нэг нь хадны зураг билээ. Хадны зураг бол хүн төрөлхтөний оюуны сэтгэлгээний анхны бүтээл төдийгүй бичгийн дурсгалтай эн зэрэгцэх түүхэн сурвалжийн нэг юм. Иймд уг дурсгалаас тухайн үеийн хүмүүсийн аж амьдрал, эрхлэх аж ахуй, нийгмийн дүр төрх, ертөнцийг үзэх үзэл, соёл зэргийг тодорхой хэмжээгээр мэдэж болно.

Манхан сумын нутагт палеолитийн үед холбогдох Гурван Цэнхэрийн агуйн алдарт зосон зураг, Ишгэн толгой сийлмэл зургаас аваад хүрэл ба төмрийн түрүү үеийн арвин баялаг хадны зургийн дурсгал бий. Эдгээр хадны зургийг өнгөрсөн зууны дунд үеэс судалж эхэлжээ. Тус сумын хадны зургийг судалсан тойм, судалгааны үр дүнг хэвлэн нийтэлсэн байдлаас үзвэл дараах байдлаар үечилж болмоор байна.

1952-1990 он. Энэ үед Монголын баруун хязгаараар хайгуул судалгаа хийж явсан дотоод гадаадын эрдэмтэд Манхан сумын нутаг буй хадны зургийн дурсгалт газрын талаар дорвитой судалгаа хийж хэвлэн нийтлүүлж байжээ.

1990-2000 он. Энэ үед өдгөөгийн ХИС-ийн багш нар оюутны хээрийн дадлага хийх явцдаа Манхан сумын нутгаас хадны зургийн дурсгалуудыг шинээр илрүүлж, эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулсан байна.

2000 оноос өдгөө хүртэл. Өнөөг хүртэл тус сумаас шинээр илэрсэн хадны зургийн дурсгалыг анхдагч баримтжуулалт хийн (фото, GPS заалт аван) өгүүлэх байдлаар оюутны дипломын ажил болон оюутны эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн байна. Иймд цаашид өгүүлэн буй сумын хадны зургуудыг судлах шаардлагатай байна.

Анх 1952 онд нэрт газар зүйч О. Намнандорж Гурван Цэнхэрийн агуйн зосон зургийг судалж хүрэл зэвсгийн үед холбогдуулан үзсэн байна (Батмөнх 2008: 20). Үүнээс хойш 1960 онд археологич Ц. Доржсүрэн, В.В. Волков нар Манхан сумын нутагт хайгуул судалгаа хийж явахдаа Бор өвдөг, Бага баавай зэрэг газраас амьтны дүрс сийлсэн хадны зураг олсон тухай нийтлүүлжээ (Волков, Доржсүрэн 1961: 51-68).

1966 онд МЗТСХЭ-ийн чулуун зэвсэг судлах анги нэрт эрдэмтэн академич А.П. Окладниковоор удирдуулан Ховд аймгийн Манхан сумын Хойт Цэнхэрийн агуйн зосон зургуудыг ахин судалж, дэлхийд алдартай Франц, Испани, Португали, Итали зэрэг баруун Европын төдийгүй дэлхий дахины хадны зураг анх үүсч хөгжсөн орнуудтай нэгэн цагт буюу дээд палеолитийн үед Монгол оронд хадны зураг үүсчээ хэмээгээд Монгол орон бол хүн төрөлхтний урлаг үүсч хөгжсөн дэлхийн нэгэн голомт юм гэсэн дүгнэлтэнд хүрсэн билээ (Окладников, 1972). Харин 1979 онд Д. Цэвээндорж (1972) Ишгэн толгойн хадны зургийг судалж палеолитийн үед холбогдуулан үзсэн байна.

1989-1990 онд ШУА-ийн Түүхийн хүрээлэнгээс Баян-Өлгий, Увс аймгийн археологийн карт зохиох ажлын явцад олон тооны хадны зургийн тухай мэдээлсэн ба А. Очир, Д. Эрдэнэбаатар (1990) нар Манхан сумын нутаг Хуурай сайрын голоос хадны зураг илрүүлэн тайлагнажээ.

1994 онд МУИС-ийн Ховд дахь салбар сургууль (хуучин нэрээр) өдгөөгийн ХИС-ийн багш түүхч Б. Батмөнх оюутны хээрийн дадлага хийх явцдаа Манхан сумын Нүхэн өтгийн хадны зургийг судалгааны эргэлтэнд шинээр оруулсан байна (Батмунх, Нямсүрэн 1997).

1997 онд Л. Нямсүрэн, Г. Пүрэвдорж нар археологийн хээрийн дадлагаар Манхан сумын нутаг Цахир хондын хадны зургийг олж нийтлүүлсэн (Нямсүрэн., Пүрэвдорж 1997: 97-98) ба А.Очир, Д. Эрдэнэбаатар нарын илрүүлсэн Манхан сумын нутаг Хуурай сайрын хадны зургийг **Цагаан голын хадны зураг** нэрээр дахин судалж видео бичлэг хийж баримтжуулжээ.

Миний бие 2010 онд Алаг толгой, Оцогийн хад, Талын харын үзүүрийн зураг зэрэг газруудад байх хадны зургуудыг бакалаврын ажилдаа мэдээлж, судалгааны анхдагч баримтжуулалт хийсэн юм (Мөнхбат, 2010: 7, 24, 26).

Өдгөө Манхан суманд нийт 10 гаруй газарт хадны зураг бүртгэгдээд байгаа ч судалгаанд огт хамрагдаагүй хадны зургийн дурсгалууд нэлээд байна. Бид энэ удаад

дээрх судалгаануудын үргэлжлэл болгож, Манхан сумын нутаг Баянтүмбэ уулын хадны зургийн тухай танилцуулж байна.

БАЯНТҮМБЭ УУЛЫН ДУРСГАЛ

Ховд аймгийн Манхан сумын төвөөс урагш 5 км-ийн зайд Төгрөгийн голоо хаяагаараа урсгаж, түүхийн бүхий л үед шүтэгдсээр ирсэн сүрлэг сайхан хайрхан бий. Уг хайрханыг нутгийнхан Баянтүмбэ гэж нэрлэдэг. Баянтүмбэ уулын хадны зургийн дурсгал ойролцоогоор умард өргөргийн $47^{\circ} 24' 610''$, дорнод уртрагийн $092^{\circ} 15' 282''$, далайн түвшнээс дээш 1580 м-т, уулын салаа ам дагуу тархсан байдалтай оршино.



Зураг 1. Ховд аймгийн Манхан сумын нутаг, Баянтүмбэ уул

Баянтүмбэ уул, түүний орчимд байх дурсгалуудыг анх 1960-аад оноос судалж эхэлжээ. 1960 оны зун Ховд аймгийн Манхан сумын төвд эртний булш олсон тухай Ховд аймгийн орон нутгийг судлах кабинетийн эрхлэгч Н. Нямгэрэл, Манхан сумын сургуулийн багш Доржравдан нар захидал, гар зургийг ирүүлснээр ШУА-ийн Түүхийн хүрээлэн мөн оны 11-р сарын сүүлчээр эртний судлагч Ц.Доржсүрэнг тэдгээр булшнуудын байдалтай танилцуулахаар илгээсэн байна. Тэр үед дээрх булш гарсан таван хэсэг газрыг хүмүүс малтан хүн, малын яс болон эд өлгийн зарим зүйлсийг олсон байв. 1961 онд дээрх булшны даланг авч барилгын ажилд ашиглаж байгаа тухай шинэ мэдээг авсан тул Түүхийн хүрээлэнгээс эртний судлагч В.В. Волков, Ц. Доржсүрэн нарыг илгээжээ. В.В. Волков, Ц. Доржсүрэн нар газар дээр нь байдалтай танилцахад таван хэсэгт хүн, малын ясны үлдэгдэл гарсны зөвхөн нэгэнд нь хүн, морины бүтэн хэлхээ яс гарсан аж. Морины толгойг өрнө зүг,

дөрвөн хөлийг умард зүг чиглүүлсэн байжээ. Морь нь эмээл хазаартай байсан авч тэдгээр нь нь ялзарч, зэвэрсэн тул авах аргагүй байсан гэх бөгөөд харин өрөөсөн дөрөө нь бараг бүтэн олдсон тул Ховд аймгийн орон нутаг судлах кабинетад хадгалсан гэж нутгийнхан мэдээлжээ. Морины хөлд толгойг өрнө зүг чиглүүлэн гэдрэг хэвтүүлсэн хүний яс байжээ. Энд хүн оршуулсан зан үйл, зүг чиг болон олдвор зэрэг нь Алтай, Өмнөд Сибирт сайн шинжилсэн чулуун дараастай булшнуудтай төсөөтэй байна. Ийм төрлийн булшийг манай эриний VI-VIII зууны үед тус улсын нутагт тогтнож байсан эртний Түрэг улсын үед холбогдоно гэж үзжээ (Доржсүрэн, 1961: 53-54).

В.В. Волков, Ц. Доржсүрэн нар дээрх малтлагын ажлаа дуусгасны дараа Манхан сумын эргэн тойрон дахь дурсгалуудтай танилцаж явахдаа Баянтүмбэ уулын баруун энгэрт орших дүгрэг, дөрвөлжин хэлбэртэй чулуун далантай хэсэг булшийг олж тэдгээрээс том, жижиг нийт 9 булш малтсан байна. Эдгээр булшнууд нь Тувагийн нутагт шинжлэгдсэн чулуун далантай булшнуудтай ижил байгааг тэмдэглээд төмөр хэрэглэж эхэлсэн үе болох НТӨ V-III зууны үед холбогдоно гэж үзжээ (Доржсүрэн, 1961: 60-64). В.В. Волков, Ц. Доржсүрэн нар Баянтүмбэ уулын энгэрт орших булшнуудыг судлан шинжилсэн боловч харин хадны зургийн дурсгалыг судлаагүй байна.

Баянтүмбийн хадны зургууд нь маш өндөрт хар хүрэн хүрмэн чулуунаа дүрслэгдсэн сийлмэл зургууд байдаг. Энд нийт 91 тооны зохиомжит зураг байгаагаас ан амьтан, явган болон морь унаад нум сум харваж буй хүн, адуу, үхэр, чоно, үл танигдах дүрс зэрэг олон сонирхолтой зургууд байна. Үүний дотроос үхрийн зургууд нь урьд өмнө Цагаан салаа, Бага Ойгорын хаданд дүрслэгдсэн үхрийн дүрслэлтэй адил байна.

Монгол орны нутагт буй хадны зургууд ихэвчлэн уулын ээвэр энгэр талд зурагдсан байдаг бол Баянтүмбэ уулын хадны зургууд эсрэгээрээ ертөнцийн зүгээр хойд зүг буюу уулынхаа ар талд зурагдсан байдаг нь уг дурсгалын нэгэн онцлог юм.

Эртний хүмүүс хадны зургийг хаа сайгүй тааралдсан газар болгоноо сийлээд байдаггүй, харин тодорхой нэгэн шүтлэгтэй газраа сийлдэг байсан бололтой (Гантулга, 2004: 63-75). Ийм газар нь тухайн нутгийн үе үеийн оршин суугчдын тахил тайлгын зан үйл гүйцэтгэн мөргөл үйлддэг, овог аймгийн баяр ёслол тэмдэглэдэг нэг ёсны байгалийн сүм дуган байжээ хэмээн үзэж болно (Батболд, Гантулга 2010: 184). Баянтүмбэ уул нь эртнээс нааш өдгөө хүртэл шүтэгдсээр байгаа шүтлэгтэй уул юм. Эрт цагт Төгрөгийн хүрээний лам нар жил бүрийн шинийн нэгний өглөө эрт Баянтүмбэ уулан дээрх овоог тахиж, гэр гарган барьж, ард олныхоо төлөө хурал номоо хурж байсан тухай нутгийнхан хуучилдаг. Овоо тахиж нь бөөгийн шашны зан үйл бөгөөд Монголд шарын шашин гүнзгийрэхэд энэ зан үйл нь шарын шашинд уламжлагдсан юм. Үүнээс үзэхэд Баянтүмбэ уулыг эрт үеэс бөөгийн зан үйлийн дагуу тахин шүтдэг байжээ.

ХАДНЫ ЗУРГИЙН ДҮР, ДҮРСЛЭЛ, ОН ЦАГИЙН ХАМААРАЛ

Баянтүмбэ уулан дах хадны зургууд нь дүрсэлсэн арга барилын хувьд ихэнх нь бодит байдлаар, бүх талбайгаар нь хонхойлгон цохиж сийлэх аргаар хийгдсэн байдаг ба ганц нэг зургийг биеийн гадаад тэгийг хөвөөлөн цохих аргаар зурсан байна (Зураг 2). Сэдэв дүрслэгдэхүүний хувьд аж байдлын, ан амьтдын болон эд зүйлсийн сэдэвтэй хэмээн ангилж болохоор байна.

ХҮН, АЖ БАЙДЛЫН СЭДЭВТ ЗУРГУУД. Баянтүмбэ ууланд хүний нийт 9 дүрслэл байгаагаас морь унасан 1, (Зураг 3. f) нум сумаар зэвсэглэсэн болон ямар нэгэн багаж зэвсэг гартаа барьсан дүрслэл 4, (Зураг 3, b, c, e, h), ямар нэгэн багаж зэвсэг барилгүй хоёр гараа алдлан зогсож байгаа дүрслэл 4 байна (Зураг 3 a, d, g, i). Эдгээрээс эх биеийг нь хөвөөлөн цохиж ерөнхий төрхийг гаргасан, онги хэлбэрийн тамга гэмээр дугуй зүйлийн хажууд гараа алдлан зогсож, байгаа эр бэлэг эрхтэн дүрсэлсэн хүний зураг ихээхэн сонирхолтой байна (Зураг 3 d). Мөн морьтой хүний дүрслэл нь дөрөөгүй, зайдан мэт бөгөөд өвөрмөц малгай өмссөн, мориных нь цулбуур газарт чирэгдэж яваа байдлаар дүрсэлжээ (Зураг 3 f). Иймэрхүү зайдан морь унасан хүний дүрслэлүүд Баян-Өлгийн Баян-энгэр, Говь-Алтайн Цагаан гол, Бигэрийн бичигтийн хад, Өмнөговийн Ноён сумын Аравжих (Дорж, Новгородова, 1975: 12, 20, 21, табл II, XIII, XXIX.рис. 2-8-4-15, рис. 2,8,4,15), болон Баян-Өлгий аймгийн Цагаан Салаа, Бага Ойгор (Кубарев и др., 2005: 633, рис. 95-17-96-2) зэрэг газрын хадны зургуудад дахь морь унасан хүмүүсийн дүрслэлтэй адилавар юм.

Энд дүрслэгдсэн ихэнх хүний дор эр бэлэг эрхтэнийг дүрсэлж эр хүн гэдгийг нь гаргасан байна (Зураг 3 d, e, g, h).

Мөн нум сум харваж байгаа хүмүүсийн нумыг дүрслэхдээ нэлээд том бүдүүнээр бодит байдлаар дүрсэлсэн (Зураг 3, b, c, e, h). Нум сум барьсан анчдын дүрслэлүүд Архангайн Батцэнгэлийн Хөрөөгийн үзүүр (Дорж, Новгородова 1975: 26-27, табл XVIII. рис.11), Баян-Өлгий аймгийн Цагаан Салаа, Бага Ойгор (Кубарев и др., 2005: 82-86, рис.80.5, 82.18, 84.6), Говь-Алтайн Цагаан гол (Доржсүрэн, 1963), Ханбогдын хадны зураг (Цэвээндорж ба бусад, 2010: 217, Табл 3, Зур. 37, 67, 68), мөн Завхан аймгийн Дөрвөлжин сумын Баян айргийн хаднаа (Цэвээндорж ба бусад, 2007: 27) дүрслэгдсэн анчдын дүртэй ижил боловч уг зохиомжтой яг адил дүрслэл бидний гар дээрх материалд хараахан мэдэгдэхгүй байна. Энэхүү нумын хэлбэр төрх нь энгийн хийцтэй, бодит, ерөнхийдөө хүрлийн үеийн хадны зурагт элбэг тохиолддог арга барилаар урласан байх ба он цагийн хувьд хүрэл зэвсгийн эхэн үед холбогдох төлөвтэй. Судлаачид нум сумаар ан хийж буй сэдэвтэй бодит байдлаар дүрсэлсэн зургуудыг ихэвчлэн хүрлийн үед холбогдуулан үздэг байна (Амартүвшин, Амгалантөгс, 2008: 40).

Эндэхийн хаднаа хүнийг дүрслэхдээ ганц нэгээр хоёр гараа дэлж, хөлөө алцайн зогссон байдалтай дүрсэлсэн байна. Ийм төрлийн зургууд нь хүрлийн үеийн дөрвөлжин хашлагат зосон зурагт ихээхэн дүрслэгдсэн байдаг. Ийм хадны зосон зургийг судлаачид хүрэл зэвсгийн үед буюу НТӨ II мянган жилийн хоёрдугаар

хагасаас НТӨ I мянган жилийн эхний хагаст холбогдуулан үздэг (Окладников, Запорожская, 1970: 89).

ҮХЭР. Баянтүмбэ уулын хадны зурагт нийтдээ дөрвөн үхрийн зураг байна (Зураг 4 а, b, с, d). Тэдний биеийг бүх талбайгаар нь хонхойлон нилээд гоёмсог дүрсэлжээ. Эдгээр дөрвөн үхрийн дүрслэлээс эхний гурван үхрийн эвэр болон ерөнхий биеийг нилээд гоёмсгоор ижил дүрсэлсэн байна. Эхний хоёр үхрийн эвэр нилээд ижил дээш босоо, сүүлийн хоёр үхрийн эвэр ижил эгц урагшаа дүрслэгдсэн байна. Харин эхний үхэр нөгөө хоёроосоо нэг зүйлээр ондоо байгаа нь түүний урд хөлөн дор дугуй зүйлийг дүрсэлсний дээр хөл нуруу хоёрыг нарийн зураасаар холбосон байна.

Үүнтэй ижил үхрийн дүрслэл Цагаан салаа Бага- Ойгор (Кубарев и др., 2005: 75-78, рис.45, 46, 47) хадны зурагт байна. Ийм зургууд неолитийн сүүл энеолитийн үед холбогддог байна. Дорнодын Тамсагбулаг, Хэрлэн голын хөндийд малтан шинжилсэн неолитын үеийн суурины орчмоос бухын толгой, эвэр зэргийг тусгай нүхэнд булж оршуулсан байжээ (Дорж, 1971).

Эдгээр үхрийн дүрслэлүүдээс нэг үхрийг биеийг нь бүдүүнээр дүрслэн хойд хөлийг дүрслэлгүйгээр зөвхөн урд хөлийг л зурсны дээр толгойн гол дундаас далбагар эвэр гаргасан дүр анхаарал татаж байна (Зураг 4 d). Үүнтэй ижил үхрийн дүрслэл Ховд аймгийн Манхан сумын Ишгэн толгойн палеолитийн үеийн хадны зурагт байна (Цэвээндорж, 1982: 6-21).

АДУУ. Баянтүмбэ уулын хадны зурагт адууны хоёр дүрслэл байна (Зураг 5). Тэдний биеийг бүх талбайгаар нь хонхойлон нилээд гоёмсог дүрсэлжээ. Уг хоёр адууны эхний адууг хоёр чихээ солбин сүүлээ унжуулан зогсож буйгаар уран, чадмаг дүрслэхдээ биеийн ерөнхий тэгийг гаргажээ. Уг хоёр адууны дүрслэл нь Хэнтий аймгийн Батширээтийн Үзүүр цохио (Дорж, Новгородова 1975: 36, табл. XXXI. рис. 6), мөн Завхан аймгийн Дөрвөлжин сумын Баян айраг (Цэвээндорж ба бусад, 2007: 30) зэрэг газрын хаднаа дүрслэгдсэн адууны дүртэй ижил байна. Судлаачид эдгээр адууны зургуудыг төмрийн түрүү үед холбогдуулан үздэг.

ЯНГИР. Баянтүмбэ уулын зурагт хамгийн их дүрслэгдсэн амьтан бол янгир юм. Янгирын нийт 35 дүрслэл байгаа ба тэднийг бүгдийг хажуу талаас нь харсан байдлаар биеийг бүх талбайгаар хонхойлон цохисон бөгөөд цөөн хэдийн биеийг гадаад тэгийг хөвөөлөн цохиж урлажээ. Мөн ганц нарийвтар зураасаар дүрсэлсэн янгирын ишгийн зураг ч тохиолдож байна.

Эдгээр зургуудаас 3 дүрслэл ихэд анхаарал татаж байна (Зураг 6: 8, 10, 29). Зураг 6, 4-8 – д нарийн зураасаар янгирын ишгийг гоёмсог зурахдаа биеийг нилээд зэгзгэр, сүүлийг дээшээ эгцээр дүрсэлсэн байна. Зураг 6, 4-10 – т урт сахалтай нэгэн янгирыг тайван хэвтэж байгаагаар дүрсэлсэн. Зураг 6, 4-29 – д нэгэн янгирыг дээшээ харайж байгаа байдалтай дүрслэхдээ эврийг нь гацуур мод мэт олон салаатайгаар зуржээ.

Энд дүрслэгдсэн ихэнх янгирын эврийг урт нумарсан, эврийн үеийг тод, богино бахим бүдүүн болон үзүүртээ бөөрөнхий том уртай зэрэг янз бүрийн байдалтай дүрсэлжээ.

Баянтүмбэ уул болон Хүйтэн хошууны зургуудад буй янгирын дүрслэл Өмнөговийн Ханбогдын Жавхлант хайрхан (Цэвээндорж ба бусад, 2004: 56), Ховд аймгийн Буянт сумын Норжинхайрхан (Мөнхбаяр, Мөнхбаатар, 2010: 234), Ховд аймгийн Манхан сумын Нүхэн өтөг (Батмунх, Нямсүрэн, 1997: 100-101) болон хөрш зэргэлдээх Тува (Дэвлет, 1976: 78) зэрэг газрын хаднаа дүрслэгдсэн янгирын дүрслэлтэй ижил байна.

АРААТАН АМЬТАД. Араатан амьтдыг хадны зурагт янз бүрийн хэлбэр төрх, хөдөлгөөн хийж байгаагаар дүрсэлсэн байдаг. Эндэхийн зургууд дотор араатан амьтдын дүрслэлүүд нилээд цөөхөн буюу 5 байна (Зураг 7 - 1, 2, 3, 4, 5).

Тухайлбал, чоныг жижиг биетэй, доош унжсан сүүл, шавхнуун гэдэстэйгээр, харин үнэгийг соотойсон чих, сагсгар сүүлтэйгээр дүрсэлсэн байх ба тэднийг давхиж байгаа, ямар нэгэн амьтан руу дайрч буй, мяраан гэтэж буйгаар харуулжээ. Иймэрхүү байдлаар дүрслэгдсэн араатан амьтдын дүрслэл Цагаан салаа, Бага Ойгор (Кубарев и др., 2005: 70-71, рис.56, 57, 58, 59) зэрэг олон газар бий.

ҮЛ ОЙЛГОГДОХ ДҮРСЛЭЛ. Баянтүмбэ уулан дах хадны зурган дотор үл ойлгогдох 8 дүрслэл (Зураг 8 - 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8) байгаагаас сонирхолтой гэмээр 2 дүрслэл байна. Түүний нэг нь ганц дан онгин тамга бөгөөд (Зураг 8 - 5) ийм дан онгин тамга Өмнөговийн Ханбогдын Жавхлант хайрхан (Цэвээндорж ба бусад, 2004: 30-32; 48-49; зураг 35, 69, 181), Хэнтий аймгийн Рашаан хад (Пэрлээ, 1975: 26, 33; Хүс. 1, 2, 3, 4, 6, 7) зэрэг олон газар дүрслэгдсэн байдаг ажээ.

ДҮГНЭЛТ

Монгол Алтайн нурууны төв хэсэгт орших Манхан сумын нутаг Баянтүмбэ уулнаас шинээр илэрсэн хадны зургуудыг танилцууллаа. Эдгээр зургууд нь уулынхаа нэг газарт биш харин олон салаа амуудын бэл, дунд хэсгээр тархсан байдалтай байна.

Баянтүмбэ уулын хадны зургуудын ихэнх нь бодит байдлаар дүрсэлсэн зургууд байх бөгөөд сэдэв, зохиомж, дүр, дүрслэлийн хувьд ан амьтад, агнуурын сэдэвтэй зургууд зонхилох боловч аж байдлын сэдэвтэй зургууд зохих байр суурийг эзлэхээс гадна тамга тэмдэг, үл танигдах дүрслэлүүд ч бас тохиолдож байна.

Тус дурсгалт газрын хадны зургийн он цагийг тодорхойлоход хүний болон бодит дүрслэлтэй үхрийн дүр онцгой бөгөөд бид Баянтүмбэ ууланд дүрслэгдсэн дөрвөн үхрийн гурвыг неолитийн сүүл энеолитийн үед, харин сүүлийн ганц үхрийг палеолитийн үед, мөн нум сум харваж буй хүний дүрслэл болон янгирын дүрийг хүрэл, төмрийн түрүү үед тус тус холбогдуулах саналтай байна.

ТАЛАРХАЛ

Энэхүү өгүүллийг бичихэд үнэтэй зөвлөгөө өгсөн МУИС-ийн багш У. Эрдэнэбат, МҮМ-н СҮЗБ-ийн албаны дарга Ж.Баярсайхан болон ХИС-ийн Түүхийн тэнхимийн багш докторант Ч. Мөнхбаяр нарт талархсанаа илэрхийлье.

НОМ ЗҮЙ

- Амартүвшин Ч., Амгалантөгс Ц., Галдан Г., 2008.* Гурван шовгор уулын хадны зураг. SA, Т. VI. Fasc. 6. УБ., 2008. Т. 40
- Батболд Н., Гантулга Ж., 2010.* Говийн бүсийн хадны зарим дурсгалууд. SA, Том. XXIX, Fasc. 21, УБ. т. 184
- Батмөнх Б., 2008.* Монгол Алтайн нурууны төв хэсэг дэхь археологийн дурсгалууд. УБ., т. 20.
- Батмунх Б., Нямсүрэн Х., 1997.* Петроглифы на скалах “Нухун утуг”. Природные условия, история и культура Западной Монголии и сопредельных регионов. Тезисы докладов III Международной научной конференции (24-26 сентября 1997 г., Ховд. Монголия). Томск: ТГУ, с. 100-101
- Волков В.В., Доржсүрэн Ц., 1961.* Ховд аймгийн Манхан сумын нутагт эртний судлалын хайгуул хийсэн тухай. SA. Т. II. f. 5. УБ., т. 51-68
- Гантулга Ж., 2004.* Хүрэл, төмрийн түрүү үеийн хадны зургийн судалгааны зарим асуудал. SA. Т. II, (XXII), Fasc. 7. УБ. т. 63-75
- Дорж Д., 1971.* Неолит восточной Монголии, УБ.
- Дорж Д., Новгородова Э.А., 1975.* Петроглифы Монголии. УБ.
- Доржсүрэн Ц., 1963.* Говь-Алтайн Цагаан голын хадны зураг. АС. Т. II, F.4, х. 12-26
- Доржсүрэн Ц., 1961.* Ховд аймгийн Манхан сумын нутагт эртний судлалын малтлага хайгуул хийсэн тухай // 1961 оны хээрийн шинжилгээний хэрэглэгдэхүүн. SA, Том II, Fasc. 2-7. УБ.
- Дэвлет М.А., 1976.* Петроглифы Улуг-Хема. М., т. 78
- Кубарев В.Д., Цэвээндорж Д., Якобсон Э., 2005.* Петроглифы Цагаан салаа и Бага-Ойгора (Монгольский Алтай). Новосибирск: Изд-во Института археологии и этнографии СО РАН, 633 с.
- Мөнхбат Ц., 2010.* Ховд аймгийн Манхан сумын нутаг дахь түүх соёлын дурсгал. Ховд, 120 тал.
- Мөнхбаяр Ч., Мөнхбаатар Б., 2010.* Монголын баруун бүс нутгийн хадны зургийн судалгаа хийгээд Норжин хайрхан уулын хадны зарим зургийн тухай. Түүхийн товчоон. Том V. Fasc 6. УБ. т. 234
- Нямсүрэн Л., Пүрэвдорж Г., 1997.* Петроглифы на скалах “Цахир хонд”. Природные условия, история и культура Западной Монголии и сопредельных регионов. Тезисы докладов III Международной научной конференции (24-26 сентября 1997 г., Ховд. Монголия). Томск: ТГУ, с. 97-98
- Окладников А. П., Запорожская В. Д., 1970.* Петроглифы Забайкалья. Ленинград
- Окладников А.П., 1972.* Центральноазиатский очаг первобытного искусства (Пещерные росписи Хойт Ценкер агуй (Сенгри-агуй), Западная Монголия). Новосибирск, 76 с.
- Очир А., Эрдэнэбаатар Д., 1990.* Баян-Өлгий аймагт ажилласан археологийн судалгааны тайлан. ТХГБС. УБ.
- Пэрлээ Х., 1975.* Монгол түмний гарвалыг тамгаар хайж судлах нь. УБ.
- Цэвээндорж Д., 1982.* Ишгэн толгойн хадны зураг. SA. Т. X. f. 2. УБ., т. 6-21
- Цэвээндорж Д., Гарамжав Д., Гүнчинсүрэн Б., Цэрэндагва Я., Гантулга Ж., Амартүвшин Ч., Мөнхбат Т., 2010.* Ханбогдын хадны зураг. УБ.

Цэвээндорж Д., Гүнчинсүрэн Б., Гантулга Ж., 2007. Баян айргийн хадны зургийн дүр, дүрслэл. SA. Т. IV. Fasc. 25. УБ.

Цэвээндорж Д., Цэрэндагва Я., Гүнчинсүрэн Б., Гарамжав Д., 2004. Жавхлант хайрханы хадны зураг. УБ.


SUMMARY

Ch. Enkhtur, Ts.Munkhbat


ROCK ARTS IN THE MOUNTAIN BAYANTUMBE

In this article we introduce briefly rock art site newly discovered in the Mountain Bayantumbe in the territory of Manhan sum of Khovd province. Most of the rock images are similar to the rock arts found in other parts of Mongolia. Nevertheless, there are some interesting images: large bull, rough man figure, and the image of a man doing and hunting same time.


These rock arts are belonged to the different historical periods from the Paleolithic to the Bronze and Early Iron Age.



Зураг 2. Баянтүмбэ ууланд илрүүлсэн хадны зураг



Зураг 3. Баянтүмбэ уулын хадны зураг дахь хүний дүрслэл




Зураг 4. Баянтүмбэ уулын хадны зураг дахь үхрийн дүрслэл




Зураг 5. Баянтүмбэ уулын хадны зураг дахь адууны дүрслэл


БАЯНТҮМБИЙН ХАДНЫ ЗУРГИЙН ДҮР, ДҮРСЛЭЛ



Зураг 6. Баянтүмбэ уулын хадны зураг дахь янгирын дүрслэл



Зураг 7. Баянтүмбэ уулын хадны зураг дахь араатан амьтны дүрслэл



Зураг 8. Баянтүмбэ уулын хадны зураг дахь үл ойлгогдох дүрслэлүүд